**Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**
**Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар**
**2024 оны IX сар**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 1. | 43 | Фестиваль зохион байгуулах тухай<br>2024-01-25<br>Дугаар 2024_41 | 3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | МУЗГ-ын 2024 оны 41 дүгээр тогтоолыг үндэслэн соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн угсаатан ястны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь сурталчлах, өвлөн уламжуулах зорилготойгоор 2024.08.16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн "Тайж" хайрханы бэлд "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль зохион байгуулагдаж, тус аймгаас Зан үйл, язгуур урлагийн багт Залуучууд театрын найруулагч Н.Баярцэнгэл ахлагчтай 17 уран бүтээлчид, бага насны өвлөн уламжлагч 4, соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, Ардын авьяастнууд 24, зохион байгуулах ажлын хэсгийн 12, нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй 3 өдрийн туршид зан үйл, язгуур хэв шинж, нутгийн болон угсаатны онцлогийг харуулж амжилттай оролцсон. Уг арга хэмжээг зохион байгуулахад Соёлын яамнаас 10.0 сая төгрөг, ЗГХА-СУГ-аас 10.0 сая төгрөг, аймгаас 28.0 сая төгрөгийн санхүүжилт үзүүлэн дэмжин тусалсан. | 100% | | |
| 2. | 44 | Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай<br>2024-02-14 | 6. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. | **2024 оны 09 дүгээр сард хэрэгжүүлсэн байдал:**<br>**Залуучууд театр:** Морин хуурч МУСТА Д.Баттулга соёл урлагийн ажилтны баярын өдрийг тохиолдуулан соёлын 7 байгууллагын ажилтан, албан хаагчдад морин хуурын сургалт явуулсан. Мөн 9-р сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдад морин хуурын үүсэл хөгжил, татлагын талаар лекц хичээл орсон. Хөгжмийн зэмсэг шинэчлэлийн хүрээнд их хуур хөгжмийг 3.8 сая төгрөгөөр худалдан авсан байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2024_59 | (5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.) | **Хүүхдийн номын ордон:** Аймгийн Соёлын салбарын залуучуудын зөвлөлөөс соёлын байгууллагын 40 гаруй ажилтан, албан хаагчдын дунд **“Морин хуурийг сурталчилан таниулах”,** сургалтыг зохион байгуулсан. **“Номтой аялал:** Хүүхдийн номын ордноор үйлчлүүлэгч хүүхэд багачуудын дунд “Номтой аялал-Морин хуур” арга хэмжээг зохион байгууллаа. Аялалд 9-р сургуулийн С.Заяасайхан багштай 8-в ангийн 20 сурагч хамрагдаж, хөгжимчин МУСТА Д.Баттулгын удирдлага дор Залуучууд театрын үйл ажиллагаатай танилцаж, Морин хуур хөгжмийн үүсэл гарал, хэрэглээ,сурах арга барилын талаар мэдээлэл авч, морин хуур хөгжмөөр үндэсний болон сонгодог зохиол бүтээлээс тоглож, хүүхэд багачууд сонирхсон асуултандаа хариулт авсан. Мөн морин хуурийн нэршлийн талаар зурагт мэдээлэл бэлтгэж пейж хуудсандаа байршуулж, 234 цахим хэрэглэгчдэд хүргэсэн.<br><br>**Шарын гол сумын Соёлын төв:** “Хөгжмийн зэмсэгийн мэдлэг олгох" боловсролын хөтөлбөрийн хүрээнд "Морин хуур"-ыг сурталчлан таниулах сургалтыг 2 удаа зохион байгуулж 54 хүүхэд, 20 том хүн хамрагдсан.<br><br>**Орхон сумын Соёлын төв:** Морин хуур хөгжмийн гарал үүсэл, хэрхэн хөгжиж ирсэн, ямар бүтэцтэй болох талаар соёлын төвийн үндэсний хөгжмийн дугуйланд суралцдаг хүүхдүүдэд сурталчилан таниулж, морин хуур хөгжимтэй холбоотой Аргасун хуурчийн домог, Хөхөө намжлын домог, Жонон харын домог зэргээс иш татан хүүхэд багачуудаас сонсож байсан эсэх талаар асууж харилцан ярилцаж “Хөхөө намжлын домог”-ийг сонсгож ажиллалаа.<br><br>**Музей:** "Морин хуур-Монгол бахархал" сургалтыг Залуучууд Театрын морин хуурч Н.Энхсайхантай хамтран зохион байгуулж, ХААИС-ийн 1-р курсийн 50 гаруй оюутнуудыг хамруулж, “Морин хуур" үндэсний хөгжмийн бүтэц, онцлог, хэрхэн тоглох талаар болон | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Музейтэй танилцаж танин мэдэхүйн мэдлэг олгов. | | | |
| 3. | 84 | 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46 | Х.3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хангалтгүй үнэлгээ авсан Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Биеийн тамир, спортын улсын хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэл, Архангай, Завхан, Дархан-Уул аймаг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулах тодорхой арга хэмжээ авч, үйл ажиллагааны үр дүнг эрс нэмэгдүүлэх ажил зохион байгуулж, гүйцэтгэлийг эргэн тайлагнах. | - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 09 дугаартай "Морин хуураа дээдлэн, дэлгэрүүлэх тухай" зарлигийг хангуулахаар аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын 2024.09.02-ны өдрийн 01/278 дугаартай албан бичгээр харьяа соёлын 7 байгууллагад хүн төрөлхтний соёлын биет бус өв, монгол үндэсний бахархал, монголчуудын түүхэн ой санамж, оюун сэтгэл, хүсэл тэмүүлэл, хийморь золын эгшгэн судар болсон арга билгийн хос чавхдаст, ая хөгийн яруу дуурьсалт морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх албан бичиг хүргүүлж, сар бүр тодорхой ажил зохион байгуулах чиглэлийг өгч ажиллалаа. | 100% | | |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУЯА

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ЦАХИМЖИЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.САРАНТУЯА